

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLI (483)

Улаанбаатар

2017

УТГА ЗОХИОЛЫН ХЭЛНИЙ ҮГИЙН САНГИЙН ХЭМ ХЭМЖЭЭНД
ГАДААД ҮГИЙН ҮҮРЭГ*

Д.Отгонцэцэг

Үгийн сан буюу үгсийн бүрэлдэхүүн нь тухайн хэлээр хэлэлцэгч улс түмний түүхийн маш урт хугацааны туршид бүрэлдэн тогтдог бөгөөд үгийн сангаас нь ард түмний эрхлэх аж ахуй, байгал цаг уурын байдал, ёс заншил зэргийг таньж болдог өвөрмөц хэсэг юм. Монголчууд төв азийн асар өргөн уудам нутаг дэвсгэрт тархан нутаглахдаа бусад улс түмнүүд, угсаатантай холилдон нутаглаж байснаас үг хэллэг харилцан бие биедээ нөлөөлж нэвтэрсэн тохиолдол их байдаг билээ. Монгол хэлний үгийн санг гарал үүслээр нь харь (заимствованное слово) ба уугуул (исконное слово) гэж ангилах (Орчин цагийн монгол хэл, 2010:336) ба харь үгийг алтай ба алтай бус хэлнээс нэвтэрсэн гэж ангилна. Монгол хэлэнд алтай бус язгуурын хэлнээс нэвтэрсэн үг хэллэг их байдаг ба харь үгийг Дорно дахин ба Европоос нэвтэрсэн гэж ангилж үздэг. Мөн гадаад хэлбэрээр нь шингэсэн ба шингээгүй гэж ангилж үзэх нь бий бөгөөд шингэсэн гэдэг нь харь үг гэдэг нь танигдахгүй байгаа, шингээгүй гэдэг нь танигдаж байгаа үг хэллэгийг хэлдэг ба монгол хэлэнд дээрх үг хэллэгээс шингээгүй үг хэллэг нь их бий. Аль ч хэлнээс бие биеэсээ харилцан үг зээлээгүй, цэвэр хэл гэж үгүй. Үг хэллэг харилцан нэвтрэнэ гэдэг нь тухайн хэлний үгийн сангийн хувьд сул дорой хэрэг бус харин тухайн улс гүрэн улс орнуудтай харилцаа холбоо их байсныг харуулж байна. Тухайлбал дэлхийн хамгийн өргөн тархсан англи хэлний үгийн сангийн 80% хувь нь гадаад үг байдаг гэж тэмдэглэсэн байдаг. Хэлний харилцан нөлөөлөл болон үгийн сангийн хөгжлийн талаар эрдэмтэн Л.Түдэв “Өвөг эртний хэл цөөхөн байжээ. Түүний үгийн сан нь ч мөн цөөхөн байсан ажээ. Тэр цөөхөн нь хэлний хөгжлийн дагуу, хүний танин мэдэхийн хүрээ тэлэхийн хамтаар үгнээс үг үүсэж, төлжсөөр олширсоор буй аж” (2009:101) гэжээ. Гадаад үг хэллэг тухайн хэлэнд амаар буюу шууд, бичгээр буюу дам орж ирэх гэсэн хоёр хэлбэр бий бөгөөд зарим талаар энэ хоёр арга хослон орсон байхыг үгүйсгэхгүй юм. Монгол хэлэнд европ хэлний үг хэллэг орос хэлээр дамжин нэвтрэч байсан бол одоо шууд нэвтрэч байна.

Монгол хэлэнд 1921 оныг хүртэл Европ үг хэллэг харьцангуй бага байсан бөгөөд 1941 оноос кирилл үсэгт шилжсэнээс хойш гадаад үгийг тэмдэглэхэд хялбар болж харь үг элбэг болжээ. Гэхдээ гадаад үг тухайн хэлний үгийн санд орж ирэх явдал нь дан ганц дээр шалтгаан бус бөгөөд улс орны улс төр, эдийн засгийн хөгжлийг дагаад харь үг нэвтрэх нь гол арга зам байдаг. 1921 оноос өмнө харь үг байсангүй гэж хэлэх гэж буй хэрэг бус бөгөөд 1920 оны 10 сарын “Нийслэлийн сонин бичиг”-т *коммун, банк, буржуй, капитал* гэх мэт байсныг харахад тухайн үед цөөнгүй гадаад үг хэрэглэж байжээ. Нэг хэлнээс нөгөө хэл рүү үг нэвтрэх дараах арга зам байна гэж үзэж байна. Үүнд:

- Газарзүйн байрлал - Хил хязгаараараа ямар ямар улстай хиллэж байгаагаас
- Худалдаа эдийн засгийн харилцаа, уламжлал - Энэ тухайд хэлэхэд монголчууд хэзээнээс

* This work was supported by Hankuk University of Foreign Studies Research Fund 2017

худалдааг урд хөрштэй хийдэг байсан ба хойд хөрштэй ийм харилцаа маш бага байснаас монгол хэлэнд орос үг харьцангуй бага байжээ.

- Хэлний гарал үүслийн харьцаа хамаарал
- Улс төрийн хараат байдал, колони орон
- Эдийн засгийн хөгжил өөрчлөлт
- Шашин суртахуун, соёл
- Тухайн улс түмний гадаад хэл сурч, зааж байсан уламжлал бөгөөд үүнээс хамгийн гол 2 шалтгаан нь худалдаа, эдийн засгийн харилцаа, улс төрийн хараат байдал зэрэг болно.

Аливаа хэлэнд харь үг хэллэг нь тухайн оронд болсон нийгэм эдийн засгийн томоохон өөрчлөлтийг даган нэвтэрдэг байна. Тухайлбал монгол хэлэнд эзэнт гүрний үед нэвтэрсэн үг хэллэг, буддын шашин дэлгэрсэн үед, манжийн дарлалд орсон үед, 1921 оны Ардын хувьсгалын үед, социализмын бүтээн байгуулалтын үед, 1990 оны Ардчилсан хувьсгалын үе, 2000 оноос хойших даяарчлалын эрин үе буюу шинжлэх ухаан техникийн их үсрэнгүй үе гэж ангилж болохоор байна. Харь үг нэвтрэх шалтгааныг эрдэмтэн О.Сүхбаатар “монгол хэлэнд янз бүрийн үг нэвтэрч ирсэн нь монгол хэлний үгийн сан бүрэлдэх, үг хэллэгийн хувьд дутуу дулимаг байснаас шалтгаалсан хэрэг огт бус харин хол ойрын улс гүрэнтэй нийгэм түүхийн янз бүрийн шатанд түүх соёл, шашин шүтлэг, улс төр, эдийн засаг худалдааны талаар өргөн харилцаатай явж ирсний баталгаа юм” гэж тэмдэглэжээ. Монгол газар усны нэрэнд харь гаралтай үг цөөнгүй байдаг нь монголчууд харь улс, угсаатантай холилдон амьдарч ирсний томоохон баталгаа юм.

Гадаад үгийн зохистой хэрэглээ бол тухайн хэлний үгийн санг баяжуулахаас гадна ялангуяа нэр томъёо оноох, шинээр зохион найруулахад гадаад үгийг өргөнөөр ашиглаж байна. Зарим судлаачид монгол хэл харь үгийн далайд живлээ, хэл мөхөх нь, монгол хэл харийн хэл болж байна хэмээн харамсан өгүүлж байна. Одоогоор монгол хэл харь үгийн нөлөөнд орж уусаж байгаатай төдийлөн санал нийлэхгүй байгаа бөгөөд сонины нэг нүүрэнд дунджаар 2000 орчим үг хэллэг байдгаас үүний 20-25 орчим харь үг буюу шингээгүй үг (европ үг) байгааг тооцоолон үзвэл нийт 2000 гаруй үгийн үгийн 2% хүрэхгүй байгаа нь эмзэглэмээр тоо бус юм. Монгол хэл мөхөх ирмэгт тулаад байгаа тухай халаглан өгүүлдэг зарим судлаачдад хандан зохиолч Б.Цэнддоо (2008) “Монгол үгээ монголоор бичих үү яах уу” нийтлэлдээ ...энэ хорвоо дээр сөнөхгүй мөхөхгүй юм гэж байхгүй, бүтэж бүрэлдсэн бүхэн хувиран арилах нигууртай хэмээн Будда Шагжмуни сургасныг бодоход хэл байтугай л юм мөхдөг байх нь. Тэр хэлээр ярих хүмүүс нь байвал хэл оршин тогтноод ярих хүнгүй бол арилаад явдаг. Тэгэхээр хүнээсээ түрүүлээд хэл алга болчих вий ярих хэлгүй болж балрах вий гэхчлэнгээр эмээх хэрэг байхгүй мэт ээ. гэж монгол хэл мөхөж байгаа талаар ярьдаг хүмүүст зөв хариулт өгсөн байна.

Харин хүмүүс харь үг их болж байна гэж байгаагийн гол шалтгаан нь ярианы хэлэнд харь үг цөөнгүй хэрэглэгдэж байгаагаас ийм дүгнэлтэд хүрсэн байх гэж таамаглаж байна. Гэвч ярианы хэл ч утга зохиолын нэг хэсэг болохоор үүнийг бас анхаарах нь зүйн хэрэг. Монгол хэлний ярианы хэлэнд бууз, хуушуур, чийдэн, цонх, байцаа, лууван, лонх, лийр гээд хятад гаралтай үг бидний ярианд элбэг байдаг бөгөөд ингэснээрээ бид хятад хэлний нөлөөнд орж буй хэрэг огтхон ч бус, бөгөөд монгол хэлэнд байгаа дорно дахины үг нэвтрээд олон зуун жил болж, харь гэдэг нь мэдэгдэхийн аргагүй уусч монгол хэлэнд хэрэглэгдсээр байгаа билээ. Харь үг хэллэг тухайн хэлэнд орж ирээд тодорхой хугацааны дараа зарим үг нь тухайн хэлний хэлзүй, дуудлагаар хэвшин тухайн хэлэнд уусдаг бол зарим нь идэвхгүй хэрэгцээт үг болох нь бий. Харь үг тухайн хэлэнд идэвхтэй байх эсэх нь тухайн үгийн хэрэглээгээс ихээхэн

хамаарна. Монгол хэлэнд байгаа европ үгийг заримыг нь өөриймшүүлж, монголчлон буулгах шаардтагатай үгхэллэг цөөнгүй бөгөөд тухайн үгийг заавал хэллэгээр дуудах шаардлагагүй байдаг. Ийм байдлаар хармаа, орос, цүнх, соосог, хулигаан, чагнаал, хундаам, оочир, лоозон гэх мэт олон үг ийм байдлаар монголжжээ. Энэ арга бол харь үгийг өөриймшүүлэх нэлээд чухал арга юм. Гэхдээ үг болгоныг ингэж буулга гэж буй хэрэг бус үүнд орчуулах шаардлагагүй экзотизм үг буюу олон улсын чанартай үг, нэр томьёо, оноосон нэр хамааралгүй билээ. Гадаад үгийн зохистой хэрэглээний талаар зарим судлаачид зүйтэй санал дэвшүүлсэн байдаг. Тухайлбал Б.Ариунтуяа “Эх хэлнээ гаднын үг орж үгийн санг баяжуулах нь бүх хэлэнд байдаг үзэгдэл тул харийн үг бүхнийг нүд үзүүрлэн гадуурхаж болохгүй. Тэдгээр үгийг аль болох утгачлан орчуулж нэршүүлж заншихын зэрэгцээ яахын аргагүй нутагшсан үгийг хэл шинжлэлд мөрддөг хуулийн дагуу дуудлагаар нь бичиж хэвших нь зөв юм” гэжээ (2009:135) Мөн доктор О.Бүрэнжаргал (2009) *Монгол хэл ба өнөө цагийн монголчууд* нийтлэлдээ “Монгол хэлний үгийн санд огт байдаггүй үгсийг гадаад үг, хэллэгээр төлөөлүүлэн оруулж монгол үг болтол нь хэрэглэсэн сайхан жишээ бий. Монголд автомашин огт байгаагүй учраас түүнийг агуулж хадгалдаг савны тухай ойлголт огт байсангүй. Хорьдугаар зууны дунд үеэс автомашин монгол хүний амьдралын хэрэгцээ болж эхэлмэгц түүнийг агуулдаг савны нэр орос хэлээр дамжин “гараж” /garage/ гэсэн гэсэн үг нэвтэрснийг монгол хэлэнд ойр дөхөм болгон “гарааш гэсэн хэллэгтэй болгосон нь ончтой төдийгүй монгол хөрсөнд хэллэгээрээ, утгаараа маш сайхан бууж идээшсэн үг болжээ. Харь үг хэдийгээр нэр томьёо боловсруулах, үгийн санг баяжуулах чухал хэрэглүүр болдог ч хэтэрч хэтийдвэл ихээхэн хор хохиролтой байдаг талаар эрдэмтэн судлаачдын санал дүгнэлт их бий (Орчин цагийн монгол хэл, 2010). Тухайлбал эрдэмтэн С.Энхжаргал, Д.Боролзой нар ...Даяаршлын хүчтэй давалгаанд англи хэл болон бусад хэлний нөлөө асар их болж, тэдгээр харь хэлээр дамжин харийн соёлыг шүтэх сөрөг үр дагавар гарч байгааг хэн бүхэн мэдсээр байгаа ч мэргэжлийн хэдэн эрдэмтэн судлаач, эх хэл, түүх соёлоо гэсэн цөөнхийн хүрээнээс хальж чадахгүй байгаа нь үнэний хувьтай гэж оновчтой дүгнэсэн (2017:13) байна. Үгийн сан зүйч Ж.Төмөрцэрэн гадаад үгийн үүрэг ялангуяа нэр томьёоны үүргийн талаар “Гадаадаас авсан үгэнд өөрийн хэлний үгээр зүүлт тайлбар хийж түүнийг олон түмэн уншигчдад ойр танил болгох (социализм - эв хамт, редактор - эрхлэгч), зарим нэр томьёог гадаад хэлнээс шууд авч хэрэглэсэн зүйл бий (автобус, ампер)” (2001:124) гэжээ.

Монголчууд өөрийн түүхэндээ Ази, Европын янз бүрийн улс үндэстэнтэй шууд ба шууд бус, өнө удаан буюу түр зуурын харилцаатай явж ирсний үр дүнд монгол хэлний үгийн санд грек, араб, самгард, иран, түрэг, төвд, хятад, манж, орос хэлний үг нэвтэрчээ” гэж зарим судлаач (Төмөрцэрэн, 2001:51) монгол хэлэнд харь үг хэрхэн нэвтэрсэн талаар дурджээ. Хэл судлалын зарим бүтээлүүдэд үүнтэй адил санал дэвшүүлсэн цөөнгүй бий (Нямжав, Нарантуяа, 2001:49). Гадаад үгийн үгийн сангийн үүрэг, ялангуяа нэр томьёо бүтээх, хэлний үгийн санг баяжуулдаг талаар доктор О.Адьяа (2005) бүтээлдээ их тодорхой, дэлгэрэнгүй бичсэн байдаг. Иймээс харь хэлний үг хэллэгт сэтгэлийн хөөрлөөр хэдийдүүлэн үнэлж адлах бус хэлний шинжлэлийн үүднээс нягт судалж эх хэлнээ зөв, зохистой хэрэглэх нь чухал юм. Монгол хэлэнд харь үг нь үгийн санг баяжуулах, нэр томьёо боловсруулах зэргээр утга зохиолын үгийн сангийн хэм хэмжээнд тодорхой үүрэгтэй байхаас гадна бид өнөөгийн даяарчлалын үед хүссэн хүсээгүй гадаад үг хэллэгээр “бөмбөгдүүлэх” л болно. Өөрөөр хэлбэл харь үгийг заримыг нь орчуулж, заримдаа өөриймшүүлж, мөн хагас орчуулж, утгачлан буулгаж, заримыг нь “төрхөмд” буцааж, хэлшинжлэлийн үүднээс нягтлан боловсруулж байвал харь үг хэллэг бол үгийн сан баяжуулах чухал арга болдог билээ.

Резюме

Language is essentially a medium of communication. It is a universal human phenomenon. With it we communicate our ideas, thoughts, emotions and messages. A language has to have the capability to express these phenomena. Sometimes, however, a language does not possess all the words necessary for it to capture all its experiences. At such times, it has to borrow words and expressions from other languages that come in contact with it. Such borrowed items help in enriching, expanding and developing the language.

Номзүй

Адъяа О. *Хэл шинжлэл, орчуулга, сурахуй, сургахуй, судлахуй*. Уб., 2005.

Ариунтуяа Б. *Эх хэлээ манахуй*. Монгол хэл бичиг-8. Уб., 2009, х.131-135.

Бүрэнжаргал О. *Монгол хэл ба өнөө цагийн монголчууд*. Үндэсний шуудан. Уб., 2009, №13.

Нямжав Д., Нарантуяа Н. *Гадаад хэл заах зүйн онол, хэрэглээ*. Уб., 2011.

Орчин цагийн монгол хэл. Уб, 2010.

Цэнддоо Б. *Монгол үгээ монголоор бичих үү яах уу*. Өдрийн сонин. Уб., 2008, №279.

Төмөрцэрэн Ж. *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Уб., 2001.

Түдэв Л. *Хэлний хүчирхийлэл (language Violence)*. Монгол хэл бичиг-8. Уб., 2009, х.196-115.

Энхжаргал С., Боролзой Д. *Эх хэлний боловсролын асуудалд*. Уб., 2017.